

ХАЛАМЖИЙН ТАЛААРХ
УДИРДАГЧИЙН ТОВЧ ЛАВЛАХ

Их Эзэний Арга Замаар Хангах нь





*Х*аламжийн төлөвлөгөөний урт хугацааны зорилго бол Сүмийн гишүүдэд, өгөгч болон хүлээн авах хэн бүхэнд эцсийн эцэст энэ Сүм оршин тогтнохын үүрэг зорилго, шалтгаан нь болсон сэтгэл санаа, оюун ухааны гүн дэх бүхнийг ил гаргаж, сүнсний нуугдмал баялгийг үр өгөөжтэй цэцэг, үр жимс болгон хувиргах зан чанарыг төлөвшүүлэх явдал мөн.

Бага Ж.Реубен Кларк, гадасны ерөнхийлөгчдийн тусгай цуглаан, 1936 оны 10-р сарын 2

ИХ ЭЗЭНИЙ АРГА ЗАМААР ХАНГАХ НЬ

Сүмийн халамжийн зорилго бол Сүмийн гишүүдэд бие даах чадвартай болоход нь тусалж, ядуучууд, тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлан, бусдад үйлчлэх явдал мөн.

Агуулга

Гишүүдийн үүрэг хариуцлага	1
Гадасны ерөнхийлөгчийн үүрэг хариуцлага	4
Бишопын үүрэг хариуцлага	4
Халамжийн тусламж үзүүлэх үндсэн зарчмууд.	5
Ядууст туслах Сүмийн нөөц боломж	5
Ядууст туслах Сүмийн бус нөөц боломж	8



Марк 12:41-44

ГИШҮҮДИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Өөрсдийнхөө төлөө, гэр бүлийнхээ болон бусдын төлөө хүлээдэг үүрэг хариуцлагаа ойлгоход нь санваартны болон Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчид гишүүдэд туслах ёстой.

Өөрийгөө болон гэр бүлээ тэтгэ

Сүмийн гишүүд сүнслэг болон материаллаг сайн сайхан байдлынхаа төлөө өөрсдөө хариуцлага хүлээх ёстой. Сүмийн гишүүд сонгох эрхийн бэлгээр адислагдсан учраас өөрсдөө шийдвэр гаргаж, асуудлаа өөрсдөө шийдэн, бие дааж амьдрах чадвартай болохын төлөө хичээн чармайх онцгой боломжтой юм. Гишүүд энэхүү онцгой боломжоо Их Эзэний

сүнслэг удирдамжаар, өөрсдийн гараар хөдөлмөрлөснөөр хэрэгжүүлдэг.

Бие даасан байдлын үзүүлэлтүүд

Бие даасан байдал нь өөрийн болон гэр бүлийнхээ хэрэгцээг хангахын төлөө хичээл зүтгэлтэй, чадвар сайтай байж, үүрэг хариуцлагаа хүлээх явдал мөн. Гишүүд бие даах чадвартай болсноор бусдад үйлчлэх, бусдыг халамжлах илүү боломжтой болдог.

Сүмийн гишүүд өөрсдийнхөө төлөө өөрөөсөө шалтгаалах бүхнийг хийсэн ч үндсэн хэрэгцээгээ хангаж чадахгүй байвал юуны өмнө гэр бүлийнхнээсээ тусламж хүсэх ёстой. Гэр бүлийн гишүүд нь туслах боломжгүй бол Сүм туслахад бэлэн байдаг.



Зарим газарт гишүүд бие даах чадвартай болохын тулд хийдэг зүйлсийг доор мөн 2-р хуудсанд харуулав.

Боловсрол. Боловсрол нь аз жаргалтай амьдрал өөд хөтөлдөг ойлголтыг баяжуулж, улам өргөжүүлэн, хөгжүүлдэг. Гишүүд судрууд болон ашигтай бусад сайн номнуудыг судалж, унших, бичих тоо бодох чадвараа хөгжүүлэн, хэрэгцээ, нөхцөл байдалдаа тохирох ажил хийхэд шаардлагатай ур чадварыг эзэмших ёстой.

Эрүүл мэнд. Их Эзэн гишүүдэд оюун ухаан, бие махбодоо арчлан хамгаалахыг зарлиг болгосон билээ. Тэд Мэргэн Ухааны Үгийг дуулгавартай дагаж, тэжээллэг хоол хүнс хэрэглэн, тогтмол дасгал хийж, хангалттай унтаж амардаг байх ёстой. Гишүүд бие махбод, оюун ухаанд хортой, донтолтод хөтөлдөг бодис буюу зуршлаас зайлсхийх ёстой. Тэд хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сайн сахиж, урьдчилан сэргийлэх үзлэг хийлгэн, шүдээ эмчлүүлж байх хэрэгтэй. Мөн гэр бүлийнхэнтэйгээ болон бусадтай нөхөрсөг харилцаатай байхыг хичээх ёстой.

Ажил эрхлэлт. Ажил хөдөлмөр бол бие даах чадвар, материаллаг сайн сайхан байдлын үндэс мөн. Гишүүд өөрийн болон гэр бүлийнхээ хэрэгцээг хангах тохиромжтой ажил эсвэл жижиг бизнес эрхлэхэд бэлтгэж,

ажил мэргэжлээ сайтар бодож ул суурьтай сонгох хэрэгтэй. Ажлын ур чадвараа байнга дээшлүүлдэг, шаргуу хичээнгүй, итгэл найдвар хүлээсэн, авч байгаа цалин, бусад тэтгэмжүүдэд нийцэхүйц шударга хөдөлмөрлөдөг байх ёстой.

Гэрийн нөөц. Өөрсөддөө болон гэр бүлдээ туслахын тулд гишүүд дараах зүйлсийг хийх ёстой. Үүнд:

- Хүнсний гурван сарын нөөцтэй байх.
- Усан хангамж бохирдох буюу тасалдах тохиолдолд хэрэглэх уух усны нөөцтэй байх.
- 3 сараас илүү хугацаанд хүрэлцэх хүнсний нөөцийг бүрдүүлэх.

All Is Safely Gathered In: Family Home Storage, 3 (зүйл 04008)-ыг үз.

Санхүү. Санхүүгийн хувьд бие даах чадвартай болохын тулд гишүүд дараах зүйлсийг хийх ёстой. Үүнд:

- Аравны нэг болон мацгийн өргөлөө төл.
- Шаардлагагүй өр зээлээс зайлсхий.
- Төсөв зохиож, түүндээ багтааж амьдар.
- Бага багаар мөнгө тогтмол хадгалсаар, улмаар хадгаламжтай бол.
- Гэр бүлийнхээ гишүүдэд мөнгө санхүүгээ зөв

зохицуулан зарцуулах зарчмуудыг заа.

All Is Safely Gathered In: Family Finances, 3 (зүйл 04007)-ыг үз.

Сүнсний хүч чадал. Хүмүүсийн материаллаг болон үүрд мөнхийн сайн сайхан байдалд сүнслэг байдал амин чухал юм. Сүмийн гишүүд Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрт итгэх итгэлээ хөгжүүлж, Бурханы зарлигуудыг дуулгавартай дагаж, өдөр бүр залбиран, судрууд болон хожмын үеийн бошиглогчдын сургаалуудыг судалж, Сүмийн цуглаануудад оролцон, Сүмийн дуудлага, бусад үүрэгт ажлуудад үйлчлэх ёстой.

Бусдыг халамжил

Аврагч мөнх бус үйлчлэлийнхээ үед ядуучууд, өвчтэй болон зовж шаналсан хүмүүсийн дунд амьдарч, тэдэнд туслан, эдгэрэлт, итгэл найдвараар тэднийг адисалж байлаа. Тэрээр шавь нартаа мөн дээрх зүйлсийг хийхийг заадаг байв. Зовж шаналагсдад туслах нь Есүс Христийн шавь нарын гол зан чанар мөн (Иохан 13:35-ыг үз).

Их Эзэн ядуучууд, тусламж хэрэгтэй хүмүүсийг анхаарч халамжлахыг өнөө үед Өөрийн хүмүүст дахин зарлиг болгосон билээ. Тэрээр, “Болгоогтун, би та нарт хэлж байна, та нар ядуус хийгээд гачигдагсдад зочлон мөн тэднийг хөнгөвчлөхийн тулд туслах ёстой” (С ба Г 44:6) гэжээ. Тусламж хэрэгтэй

хүмүүст хувиараа нигүүлсэнгүй сэтгэлийн үйлчлэл үзүүлэхэд Сүмийн гишүүдийг урамшуулан дэмждэг. Тэд гуйлгалгүйгээр эсвэл үүрэг даалгавар авалгүйгээр “сайн зарчимд санаа сэтгэлээ бүрэн зориулж” үйлчлэх ёстой (С ба Г 58:26–27-г үз).

Их Эзэн ядуучууд, тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлах Өөрийн арга замыг тайлбарласан юм. Тэрээр Гэгээнтнүүдэд “та нар эд юмсаа ядуустай хуваалцаж, [энэ нь] бишопын өмнө тавигдаж, үлдсэн нь ядуус хийгээд гачигдагсдад өгөхийн тул миний агуулахад хадгалагдах ёстой” (С ба Г 42:31, 34) гэж зааварчилжээ.

Их Эзэн эдгээр өргөлүүдэд гишүүдийн авьяас чадвар орох ёстойг цааш нь тайлбарласан юм. Эдгээр авьяас чадвар “Их Эзэний агуулахад хийгдэж, хүн болгон хөршийнхөө анхаарал тусламжийг эрэлхийлж мөн бүх зүйлийг Бурханы алдар суугийн төлөө бүхнээ зориулан хийх ёстой” (С ба Г 82:18–19).

Их Эзэний агуулах нь ядууст хоол хүнс тараах төдийгөөр хязгаарлагддаггүй. Үүнд ядуус болон тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлахад зориулан бишоптоо өгсөн, итгэлтэй гишүүдийн цаг зав, авьяас чадвар, энэрэл хайр, эд материалын болон санхүүгийн туслалцаа ордог. Тиймээс Их Эзэний агуулах тойрог бүрд байдаг. Бишоп нь Их Эзэний агуулахыг хариуцагч төлөөний хүн юм.

ГАДАСНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Бишопууд халамжийн зарчмуудыг ойлгодог, ядуусыг эрж олон, халамжлах бурханлиг үүргээ биелүүлдэг байхад гадасны ерөнхийлөгчийн зөвлөл анхаарна. Гадасны ерөнхийлөгч бишопуудтай зөвлөлдөж, мацгийн өргөл болон зарцуулалтыг нь хамтран хянадаг.

Бишопын агуулах, ажил эрхлэлтэд дэмжлэг үзүүлэх төв зэрэгт халамжийн үйл ажиллагаануудыг санваартны удирдлагаар хангахын тулд гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийг томилж болно.

Сүмийн янз бүрийн асуудал, түүний дотор халамжийн зарчмууд болон үүрэг хариуцлагын

талаар заавар хүлээн авахын тулд гадасны ерөнхийлөгчид зохицуулах зөвлөлийн хурлуудад оролцоно. Удирдагчид эдгээр хурлуудаар бие даах чадварт дэмжлэг үзүүлэх, тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлах, мацгийн өргөлийг урамшуулан дэмжих зэрэг асуудлуудыг хэлэлцдэг.

Гадасны ерөнхийлөгчид бас гадас дундын халамжийн үйл ажиллагаа, онцгой байдлын үед авах арга хэмжээг зохицуулна.

БИШОПЫН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Бишоп ядуусыг эрж олон, халамжлах бурханлиг үүрэг хүлээдэг (С ба Г 84:112-ыг үз). Тэр тойргийнхоо халамжийн ажлыг удирдан чиглүүлнэ.



Бишоп тусламж хэрэгтэй байгаа гишүүдтэй уулзаж, амьдралаа өөд нь татахад тэдэнд хэрхэн тусалж болох талаар ярилцана.

Түүний зорилго бол амьдралаа өөд татан, бие даах чадвартай болоход нь гишүүдэд туслах явдал юм. (Салбаруудад салбарын ерөнхийлөгч халамжлах үүрэг хариуцлагыг хүлээдэг.)

Бишопууд тусламж хэрэгтэй хүмүүст туслах хамгийн сайн арга замыг ялган таних бэлгээр адислагдсан байдаг. Хувь хүн бүрийн нөхцөл байдал өөр өөр бөгөөд сүнслэг удирдамжийг шаарддаг. Бишоп энэ хэсэгт тайлбарласан халамжийн үндсэн зарчмууд болон Сүнсээр удирдагдан хэнд, хэдий хэмжээний, ямар тусламжийг ямар хугацаанд үзүүлэхийг тогтооно.

Ерөнхийдөө, бишоп зөвхөн тухайн үед тойргийн нутаг дэвсгэрт оршин сууж буй гишүүдэд тусална. Цөөхөн тохиолдолд бишоп Сүнсний удирдамжаар Сүмийн гишүүн бус хүмүүст тусламж үзүүлж болно.

Бишоп гишүүдийн халамжийн хэрэгцээний нууцыг хадгална. Тэр зөвхөн санваартны болон Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчид эсвэл тусламж өгч байгаа бусад хүмүүстэй мэдээллийг хуваалшана.

Халамжийг буруугаар ашигласан, луйвар хийсэн асуудалтай тулгарсан бишопууд бишопт зөвлөгөө өгөх утсаар (1-801-240-7887) эсвэл хариуцсан бүсийн албанд утасдаж болно. Бишоп тухайн гишүүнийг мэдэхгүй бол өмнө нь халамжийн

тусламж өгч байсан бишоптой нь холбоо барих ёстой.

ХАЛАМЖИЙН ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ ҮНДСЭН ЗАРЧМУУД

Бишоп ядуус болон тусламж хэрэгтэй хүмүүсийг халамжлахдаа дараах үндсэн зарчмуудыг баримтлах ёстой:

- **Ядуусыг эрж ол.** Зөвхөн хүсэлт тавьсан үед туслах нь хангалтгүй. Бишоп санваартны болон Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчдыг гэрийн болон айлчлагч багш нартай хамтран тусламж хэрэгтэй хүмүүсийг олж тогтооход дэмжих хэрэгтэй.
- **Хувийн хариуцлагыг дээшлүүл.** Бишоп гишүүнтэй хамтран түүнд болон гэр бүлд нь хэрэгцээгээ хангах ямар нөөц боломж, чадавх байгааг судалж үзнэ.
- **Амьдралын хэв маягт нь биш, амь зуулгад нь дэмжлэг үзүүл.** Бишоп амь зуулгын үндсэн хэрэгцээт зүйлсээр хангахаас биш, хэн нэгнийг чинээлэг амьдралтай болгохын тулд тусламж үзүүлдэггүй.
- **Бэлэн мөнгө биш, эн тэргүүний хэрэгцээт зүйлс өг.** Боломжтой бол бишоп гишүүдэд бэлэн мөнгө өгөх эсвэл мөнгөн төлбөрийг нь төлөхийн оронд тэднийг эн тэргүүний хэрэгцээт зүйлсээр хангах хэрэгтэй. Бишопын агуулахгүй газарт



Бишопын удирдлага дор тойргийн зөвлөл халамжийн хэрэгцээг шийдвэрлэхэд тусална.

мацгийн өргөлийг эн тэргүүний хэрэгцээт зүйлс худалдаж авахад ашиглаж болно.

- **Ажил хийх боломж олго.**

Бишоп тусламж авсан хүмүүсээс хэр чадалдаа тохирсон ажил хийхийг хүсэх ёстой. Бишоп ажил хөдөлмөрийн ач холбогдлыг зааж, үр өгөөжтэй ажлыг даалган хийлгэнэ. Тойргийн зөвлөл үр өгөөжтэй ажлуудын жагсаалт гаргаж, эдгээр ажлуудыг тусламж авсан хүмүүсээр хийлгэх хэрэгтэй.

Ядууст туслах Сүмийн нөөц боломж

Тойргийн зөвлөл


Тойргийн зөвлөлийн гишүүд, ялангуяа санваартны чуулгууд

болон Нийгмийн Халамжийн Бүлэг гишүүдийн халамжийн хэрэгцээг хангах ажилд бишопт тусалдаг. Эдгээр удирдагчид гэрийн болон айлчлагч багш нар, онцгой авьяас чадвартай бусад хүмүүсээр туслуулна.

Санваартны гүйцэтгэх хоороны хурлаар нууц асуудлуудыг хэлэлцэхэд шаардлагатай бол Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөлийг оролцуулж болно.

Санваартны чуулгууд болон Нийгмийн Халамжийн Бүлэг

Халамж бол санваартны чуулгууд болон Нийгмийн Халамжийн Бүлгийн гол үүрэг мөн. Халамжийн асуудлуудыг ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлаар тогтмол хэлэлцэж байх ёстой. Санваартны чуулгууд болон Нийгмийн Халамжийн Бүлэг



Тохиромжтой үед бишоп тойргийн Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийг гишүүдийн гэрээр очиж уулзан, хэрэгцээг нь судалж, ямар тусламж шаардлагатайг тогтооход өөртөө туслуулахаар үүрэг өгдөг.

халамжийн хэрэгцээнийхээ шийдлийг олж, бие даах чадвартай болоход нь гишүүдэд бишопын удирдлагаар тусална.

Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч

Өмнөх догол мөрүүдэд тайлбарласан халамжийн үүргүүдээс гадна Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч халамжийн тусламж хэрэгтэй байгаа гишүүдтэй гэрээр нь очиж уулзан, бишопт тусална. Тэрээр хэрэгцээгээ тодорхойлоход нь тэдэнд тусалж, ямар тусламж хэрэгтэй байгааг бишопт санал болгоно. Бишоп болон Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч Хэрэгцээ ба эх үүсвэрийн шинжилгээний маягт (зүйл 32290)-ыг ашиглаж болно.

Тойргийн халамжийн зохицуулагчид

Бишопын зөвлөл ажил эрхлэлтийн болон халамжийн бусад зохицуулагчдыг дуудаж болно. Эдгээр зохицуулагчид нь тойргийнхоо бусад гишүүдэд ажил олох, боловсролтой болох, сургалтанд хамрагдах, хүнсний тэжээллэг чанарыг эрхэмлэн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих, Боловсролын Тасралтгүй Сан, гэрийн нөөц, эрүүл мэнд, гэр бүлийн санхүү болон халамжийн бусад хэрэгцээг өөрсдөө хангахад нь туслах, тухайн тойргийн гишүүд байх ёстой.

Мацгийн өргөл ба аравны нэг

Их Эзэн Өөрийн хүмүүсийг адислахын тулд аравны нэгийн хууль, мацгийн хуулийг өгсөн билээ. Уг хуулинд мацгийн

өргөл багтдаг (Исаиа 58:6–12; Малахи 3:8–12-ыг үз). Мацгийн өргөл нь зөвхөн халамжийн хэрэгцээг хангахад зориулагддаг.

Бишоп тойргийнхоо зөвлөлийн туслалцаатайгаар эдгээр хуулиудаар амьдрахын ач холбогдлыг бүх гишүүдэд заадаг. Мөн эдгээр хуулиудаар амьдарснаар ирдэг Их Эзэний амлалтуудын тухай заадаг. Эдгээр амлалтуудад Их Эзэнд улам ойр дотно байх мэдрэмж, бусдыг гэсэн агуу нигүүлсэнгүй сэтгэл багтдаг билээ. Их Эзэн бас бидний сүнсний хүч чадал өсөн нэмэгдэж, материаллаг амьдрал ахуй сайжрахыг, үйлчлэх хүсэл улам хүчтэй болохыг амладаг.

Дэлхийн зарим бүсэд бишопын агуулахууд хоол хүнс, хувцас хунараар хангадаг. Бишопын агуулахгүй газруудад мацгийн өргөлийг хоол хүнс, хувцас хунараар хангахад ашигладаг. Мацгийн өргөлийг бас орон гэртэй болох, эрүүл мэндийн тусламж болон амь зуулгын бусад хэрэгцээнд туслахын тулд ашигладаг.

Тусламж хэрэгтэй гишүүний эмчилгээний зардалд нэмэлт зөвшөөрөл авалгүйгээр бишопын төлж болох мөнгөний дээд хэмжээг Сүмийн Халамжийн ерөнхий хороо тогтоосон юм. Мацгийн өргөлийг ашигласан тохиолдолд хамгийн ойрын, тохиромжтой эмнэлгийн байгууллагаас эрүүл мэндийн үйлчилгээг авах ёстой.

Мацгийн өргөлөөс гаргасан зардал, мацгийн өргөлийн нийт дүнтэй заавал тэнцүү байх шаардлагагүй.

Халамжийн тусламж нь Сүмийн гишүүдийн төлөө зориулагдах бөгөөд ерөнхийдөө мацгийн өргөлийн хандиваар санхүүждэг. Сүмийн хүмүүнлэгийн тусламж нь бүх шашны хүмүүст зориулагдах бөгөөд ерөнхийдөө хүмүүнлэгийн тусламжийн хандиваар санхүүждэг.

Гадасны болон Сүмийн бусад нөөц боломж

Хэрэв дараах нөөц боломж байгаа бол бишоп гишүүдийн хэрэгцээнд туслахын тулд гадасны зохицуулагчид, Сүмийн ажил эрхлэлтийн төв, бишопын агуулах, Дезерет Индастриес болон ХҮГ Гэр бүлийн хөтөлбөр зэрэгт хандаж болно.

Ядууст туслах Сүмийн бус нөөц боломж

Гишүүд үндсэн хэрэгцээгээ хангахын тулд нийгмийн, түүний дотор засгийн газрын нөөц боломжийг ашиглахаар сонгож болно. Бишоп эдгээр нөөц боломжийг мэддэг байх ёстой. Эдгээр нөөц боломж нь:

- Эмнэлэг, эмч нар, эрүүл мэнд, эмчилгээ, сувиллын бусад байгууллагууд.
- Ажил мэргэжлийн сургалт болон ажилд зуучлах байгууллагууд.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан тусламж.
- Мэргэжлийн зөвлөгөө өгөгчид, нийгмийн ажилтнууд.
- Донтолтыг эдгээх хөтөлбөрүүд юм.

Сүмийн гишүүд Сүмийн бус эх үүсвэрүүдээс тусламж авлаач тэдгээрээс хамааралтай болохоос зайлсхийхэд нь бишоп тэнд туслах ёстой.



Матай 25:35–36, 40

Энэ товхимол нь халамжийн үндсэн зарчмуудын товч лавлах, санваартны болон Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчдад зориулсан бие даах чадварын үндсүүд юм. Нэмэлт мэдээллийг *Их Эзэний арга замаар хангах нь: Халамжийн талаарх удирдагчийн товч лавлах* товхимлоос үзэж болно. Уг товхимлыг Сүмийн Хангамжийн Төвөөс авч болно. Мөн providentliving.org-аас үз.

Хавтас: *Христ Бетесдад өвчтөнийг эдгээсэн нь*, Карл Хейнрих Блок, Бригам Янгийн Их Сургуулийн Урлагийн музейн зөвшөөрлөөр нийтлэв

Нүүрэн талын дотор хавтас: *Христ ба баян залуу*, Хейнрих Хофман, С. Harrison Conroy Co., Inc-ийн зөвшөөрлөөр нийтлэв
Эхний хуудас 1: *Бэлэвсэн эмэгтэйн жижигхэн зэс зоос*, Александр Байда. Хуудас 1: Гэрэл зургийг © Robert Casey
Ар талын дотор хавтас: *Хотынхон бүгдээрээ цугласан байлаа*, Жеймс Тиссот

© 2009 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан. Америкийн Нэгдсэн Үлсад хэвлэв.

Англи эхийн зөвшөөрөл: 12/08. Орчуулгын зөвшөөрөл: 2018.

Providing in the Lord's Way: Summary of a Leader's Guide to Welfare. -гийн орчуулга. Mongolian. 08257 363

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс хэвлэн гаргав. Юта муж улс, Солт Лейк хот

Бидний үндсэн зорилго бол . . . тэтгэмж аван,
үр бүтээлгүйгээр залхууран суух хөнөөлт хилэнцийг
хүмүүсийнхээ дунд үгүй болгох тогтолцоог бий болгож,
бие даах чадвар, ажилч хичээнгүй, арвич хямгач чанар, өөрийгөө
хүндэтгэх явдлыг байнгын хэвшил болгон хөгжүүлэх явдал юм.
Сүмийн зорилго бол хүмүүс амьдралаа өөрсдөө өөд татан
авч явахад нь тэдэнд туслах явдал мөн.
Ажил хөдөлмөр бол Сүмийн гишүүдийн амьдралыг
нь удирдан чиглүүлэгч гол зарчим мөн.

Тэргүүн Зөвлөл, Ерөнхий Чуулганы Илтгэлд, 1936 оны 10-р сар, 3

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

